

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2026/027/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот

2026он

Дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва

Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн

Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,320,400.00	5,921,400.00
БАРАА МАТЕРИАЛ	6,320,400.00	5,921,400.00
Түүхий эд материал	2,733,400.00	5,921,400.00
Тусгай зориулалттай материал	2,733,400.00	5,921,400.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	231,554,029.34	223,679,188.33
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	231,554,029.34	223,679,188.33
Биет хөрөнгө	230,206,529.34	222,661,688.33
Барилга, байгууламж, орон сууц	45,517,867.23	45,517,867.23
Хуримтлагдсан элэгдэл	-6,263,117.32	-7,321,672.36
Авто-тээврийн хэрэгсэл	42,000,000.00	15,000,000.00
Машин тоног төхөөрөмж (компьютер)	181,908,926.52	176,532,200.00
Хуримтлагдсан элэгдэл	-39,998,841.09	-58,118,198.98
Тавилга, аж ахуйн эд хогшил	65,300,802.00	66,476,932.00
Хуримтлагдсан элэгдэл	-16,259,108.00	-15,425,439.56
Биет бус хөрөнгө	1,347,500.00	1,017,500.00
Программ хангамж	1,650,000.00	1,650,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-302,500.00	-632,500.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	237,874,429.34	229,600,588.33
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	237,874,429.34	229,600,588.33
Засгийн газрын хувь оролцоо	237,874,429.34	229,600,588.33
Хуримтлагдсан үр дүн	237,874,429.34	210,926,708.33
Өмнөх үеийн үр дүн	237,874,429.34	237,874,429.34
Тайлант үеийн үр дүн	0.00	-26,947,721.01
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	18,673,880.00
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	237,874,429.34	229,600,588.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	721,662,200.00	620,404,804.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,720,000.00	14,000,000.00
Нийтлэг татварын бус орлого	34,720,000.00	14,000,000.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	34,720,000.00	14,000,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,720,000.00	14,000,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	686,942,200.00	606,404,804.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	27,406,804.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	10,921,804.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	16,485,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	686,942,200.00	578,998,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	686,942,200.00	578,998,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	683,022,640.32	639,680,508.05
УРСГАЛ ЗАРДАЛ	683,022,640.32	639,680,508.05
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	496,263,466.86	450,494,990.63
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,231,579.00	322,699,199.61

Цалин	161,236,736.00	141,042,289.61
Цалингийн тусгай нэмэгдлүүд	195,994,843.00	181,656,910.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,627,382.64	38,764,798.97
Тэтгэврийн даатгал	35,867,527.80	33,713,532.42
Эрүүл мэндийн даатгал	6,759,854.84	5,051,266.55
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	1,383,525.00
Түлш, халаалт	0.00	1,383,525.00
Хангамж, бараа материалын зардал	17,465,712.90	12,957,671.00
Бичиг хэрэг	12,317,300.00	9,335,800.00
Тээвэр, шатахуун	1,610,000.00	1,300,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	790,012.90	901,115.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,748,400.00	1,420,756.00
Эд хогшил, урсгал засварын зардал	413,000.00	11,459,000.00
Урсгал засвар	413,000.00	11,459,000.00
Томилолт, зочны зардал	25,220,100.00	9,635,000.00
Дотоод албан томилолт	25,220,100.00	9,635,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,424,852.00	11,645,092.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,380,000.00	10,031,500.00
Даатгалын үйлчилгээ	400,000.00	117,612.00
Тээврийн хэрэгслийн татвар	212,852.00	142,980.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,410,000.00	1,331,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	28,880,840.32	41,950,704.05
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	2,000,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,880,840.32	39,950,704.05
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	186,759,173.46	189,185,517.42
Бусад урсгал шилжүүлэг	131,711,587.00	54,475,324.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,233,600.00	7,479,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,672,087.00	46,996,324.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	55,047,586.46	134,710,193.42
Төвлөрүүлэх шилжүүлэг	55,047,586.46	134,048,389.42
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		661,804.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	38,639,559.68	-19,275,704.05
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	7,672,016.96
Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		7,672,016.96
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-7,672,016.96
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	38,639,559.68	-26,947,721.01

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	721,662,200.00	620,404,804.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,720,000.00	14,000,000.00
Нийтлэг татварын бус орлого	34,720,000.00	14,000,000.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	34,720,000.00	14,000,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,720,000.00	14,000,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	686,942,200.00	606,404,804.00

Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	27,406,804.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	10,921,804.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	16,485,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	686,942,200.00	578,998,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	686,942,200.00	578,998,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	658,996,900.00	599,330,804.00
УРСГАЛ ЗАРДАЛ	658,996,900.00	599,330,804.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	472,237,726.54	410,145,286.58
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,231,579.00	322,699,199.61
Цалин	161,236,736.00	141,042,289.61
Цалингийн тусгай нэмэгдлүүд	195,994,843.00	181,656,910.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,627,382.64	38,764,798.97
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	35,867,527.80	33,713,532.42
Эрүүл мэндийн даатгал	6,759,854.84	5,051,266.55
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	1,383,525.00
Түлш, халаалт	0.00	1,383,525.00
Хангамж, бараа материалын зардал	18,733,812.90	13,417,671.00
Бичиг хэрэг	13,601,800.00	9,795,800.00
Тээвэр, шатахуун	1,593,600.00	1,300,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	790,012.90	901,115.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,748,400.00	1,420,756.00
Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	10,071,000.00
Багаж, техник, хэрэгсэл		590,000.00
Урсгал засвар	4,000,000.00	9,481,000.00
Томилолт, зочны зардал	25,220,100.00	9,635,000.00
Дотоод албан томилолт	25,220,100.00	9,635,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,424,852.00	12,174,092.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,380,000.00	10,031,500.00
Даатгалын үйлчилгээ	400,000.00	117,612.00
Тээврийн хэрэгслийн татвар	212,852.00	142,980.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,410,000.00	1,860,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,000,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	2,000,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	186,759,173.46	189,185,517.42
Бусад урсгал шилжүүлэг	131,711,587.00	54,475,324.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,233,600.00	7,479,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,672,087.00	46,996,324.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	55,047,586.46	134,710,193.42

Төвлөрүүлэх шилжүүлэг	55,047,586.46	134,048,389.42
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		661,804.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>62,665,300.00</u>	<u>21,074,000.00</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	62,665,300.00	21,074,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	62,665,300.00	21,074,000.00
Дотоод эх үүсвэрээр	62,665,300.00	21,074,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	62,665,300.00	21,074,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-62,665,300.00</u>	<u>-21,074,000.00</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	0.00	237,874,429.34	237,874,429.34
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	0.00	237,874,429.34	237,874,429.34
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	0.00	237,874,429.34	237,874,429.34
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	0.00	237,874,429.34	237,874,429.34
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт, бууралт	-	18,673,880.00	0.00	18,673,880.00
Тайлант үеийн үр дүн	-	0.00	-26,947,721.01	-26,947,721.01
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	18,673,880.00	210,926,708.33	229,600,588.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	607,998,000.00	458,949,610.58	149,048,389.42	75.5
УРСГАЛ ЗАРДАЛ	607,998,000.00	458,949,610.58	149,048,389.42	75.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538,512,000.00	404,474,286.58	134,037,713.42	75.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	421,182,500.00	322,699,199.61	98,483,300.39	76.6
Цалин	168,514,500.00	141,042,289.61	27,472,210.39	83.7
Цалингийн тусгай нэмэгдлүүд	252,668,000.00	181,656,910.00	71,011,090.00	71.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,647,800.00	38,764,798.97	13,883,001.03	73.6
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	44,224,100.00	33,713,532.42	10,510,567.58	76.2
Эрүүл мэндийн даатгал	8,423,700.00	5,051,266.55	3,372,433.45	60.0

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,865,900.00	1,383,525.00	1,482,375.00	48.3
Түлш, халаалт	2,865,900.00	1,383,525.00	1,482,375.00	48.3
Хангамж, бараа материалын зардал	14,966,200.00	13,417,671.00	1,548,529.00	89.7
Бичиг хэрэг	10,000,000.00	9,795,800.00	204,200.00	98.0
Тээвэр, шатахуун	1,400,000.00	1,300,000.00	100,000.00	92.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,158,600.00	901,115.00	257,485.00	77.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,407,600.00	1,420,756.00	986,844.00	59.0
Эд хогшил, урсгал засварын зардал	4,400,000.00	4,400,000.00	0.00	100.0
Урсгал засвар	4,400,000.00	4,400,000.00	0.00	100.0
Томиллолт, зочны зардал	19,520,000.00	9,635,000.00	9,885,000.00	49.4
Дотоод албан томиллолт	19,520,000.00	9,635,000.00	9,885,000.00	49.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,929,600.00	12,174,092.00	7,755,508.00	61.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,814,000.00	10,031,500.00	3,782,500.00	72.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,280,000.00		2,280,000.00	0.0
Даатгалын үйлчилгээ	400,000.00	117,612.00	282,388.00	29.4
Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	142,980.00	257,020.00	35.7
Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	22,000.00	28,000.00	44.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,985,600.00	1,860,000.00	1,125,600.00	62.3
Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	2,000,000.00	1,000,000.00	66.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	2,000,000.00	1,000,000.00	66.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,486,000.00	54,475,324.00	15,010,676.00	78.4
Бусад урсгал шилжүүлэг	69,486,000.00	54,475,324.00	15,010,676.00	78.4
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,086,000.00	7,479,000.00	8,607,000.00	46.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	53,400,000.00	46,996,324.00	6,403,676.00	88.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	607,998,000.00	458,949,610.58	149,048,389.42	75.5
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	593,998,000.00	444,949,610.58	149,048,389.42	74.9
Орон нутгийн төсвөөс	593,998,000.00	444,949,610.58	149,048,389.42	74.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,000,000.00	14,000,000.00	0.00	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,000,000.00	14,000,000.00	0.00	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	10.00	10.00	0.00	100.0
Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	0.00	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	10.00	10.00	0.00	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7.00	7.00	0.00	100.0

Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.00	3.00	0.00	100.0
--	------	------	------	-------

2.6 Аудит хийсэн орон нутгийн дансны төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,406,804.00	26,745,000.00	661,804.00	97.6
УРСГАЛ ЗАРДАЛ	27,406,804.00	26,745,000.00	661,804.00	97.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,406,804.00	26,745,000.00	661,804.00	97.6
Эд хогшил, урсгал засварын зардал	27,406,804.00	26,745,000.00	661,804.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	16,485,000.00	16,485,000.00	0.00	100.0
Тавилга	5,829,000.00	5,179,000.00	650,000.00	88.8
Урсгал засвар	5,092,804.00	5,081,000.00	11,804.00	99.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	27,406,804.00	26,745,000.00	661,804.00	97.6
Нэмэлт санхүүжилтийн орлого	27,406,804.00	26,745,000.00	661,804.00	97.6
ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,921,804.00	10,260,000.00	661,804.00	93.9
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,485,000.00	16,485,000.00	0.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөн ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах байгууллага байна.

Эрхэм зорилго: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу хариуцлагатай, ил тод, нээлттэй зохион байгуулан тэгш, шударга өрсөлдөх таатай орчинг бүрдүүлэх замаар төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд оршино.

Зорилт:

1. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хүрээнд нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэн төлөвлөх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих тайлагнах
2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд худалдан авах ажиллагааны талаар мэргэжил, арга зүйгээр талуудыг хангах, сургалт зохион байгуулах, цахим худалдан авах ажиллагааны талаар мэдээллийг орон нутгийн захиргааны байгууллагуудыг хангах, худалдан авах ажиллагаа дахь орон нутгийн иргэдийн оролцоог дэмжиж, бусад улсын туршлагыг нэвтрүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах
3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, газрын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах замаар захиргааны удирдлагын манлайллыг хангах

Дээрх зорилтуудын хүрээнд 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 85.6 оноотой дүгнүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

- Монгол Улсын үндсэн хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухайн хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70.5-д "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно." гэж нэмсэн.
- Газрын даргын 2025 оны А/19 дүгээр тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн баталжээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж үзлээ.

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь Дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан байхгүй байна. Дотоод аудитын чиг үүргийг ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Үйл ажиллагаандаа 2023 оны А/255 дугаар захирамжаар баталсан "Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,273.8 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	6,320.4	5,921.4	-399.0
Үндсэн хөрөнгө	231,554.0	223,679.2	-7,874.8
Нийт хөрөнгө	237,874.4	229,600.6	-8,273.8
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	237,874.4	229,600.6	-8,273.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	237,874.4	229,600.6	-8,273.8

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлагын дансны үлдэлдэлгүй байна.

Бараа материалын дансны бууралт нь барилга засварын материалын эхний үлдэгдлийн бууралтаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн данснаас дахин үнэлгээтэй холбоотойгоор болон аймгийн Засаг даргын 2025 оны А/541, А/709, А/1104 дугаар захирамжаар нийт 70,948.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 63,276.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг данснаас хассан байна. Үндсэн хөрөнгийн дансны бууралт нь эдгээр хөрөнгийн хөдөлгөөн болон элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 608,775.6 мянган төгрөгөөр бүрдүүлж, нийт зарлагыг 608,775.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 776.6 мянган төгрөгөөр бууруулж 607,998.0 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн саналаас цалин, НДШ-ийн зардлыг 23,876.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, томилолтын зардлыг 700.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 750.0 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 22,725.8 мянган төгрөгөөр бууруулж баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70418 /Худалдан авах ажиллагаа/ хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 593,998.0 мянган төгрөгийг, өөрийн орлогоос 14,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцсон байна.

Гүйцэтгэлээр 15,000.0 мянган төгрөгөөр дутуу буюу 578,998.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс хүлээн авч, өөрийн орлогыг бүрэн бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд нийт 458,949.6 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдлийг буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 458,949.3 мянган төгрөг буюу 75.5 хувьтай байгаа цалин, НДШ-ын зардлыг 112,366.3 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 1,482.4 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 1,548.5 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 9,885.0 мянган төгрөгөөр, төлбөр хураамжийн зардлыг 7,755.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,000.0 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 15,010.7 мянган төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Худалдан авах ажиллагаа	607,998.0	458,949.6	149,048.4	75.5%
1.1	Үндсэн үйл ажиллагаа	523,488.0	394,492.8	128,995.2	75.4%
1.2	Мэдээлэл, сурталчилгаа	10,814.0	9,000.0	1,814.0	83.2%
1.3	Хүүхэд хамгаалал	4,210.0	981.5	3,228.5	23.3%
1.4	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	69,486.0	54,475.3	15,010.7	78.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 27,406.8 мянган төгрөгийн орлого хүлээн авч, 26,745.0 мянган төгрөгийг зарцуулж тайлагнасан байна

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тусгайлан нэмэлтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй болно.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Урсгал зардалд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах үнийн дүн бүхий зардлын зүйл анги тусгагдаагүй бөгөөд төсвийн сар, улирлын хуваарийн дагуу бараа бүтээгдэхүүнийг шууд гэрээ байгуулан болон нэхэмжлэхээр худалдан авсан байна.

Оны эцэст давсан орлогыг зарцуулах зөвшөөрөл авч нэмэлт санхүүжилтийн дансаараа хамт олны хурлын шийдвэрийг үндэслэн 16,485.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, газрын дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва нар тус тус хэрэгжүүлээ.

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн дүнгүүд нь харилцан адилгүй буюу хөрөнгийн дүн харьцангуй бага, нийт орлого нь тухайн онд хүлээн авсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос хамаарч хэлбэлздэг бөгөөд төсвийн байгууллага нь батлагдсан төсвийн хүрээнд зардлын ангиллаар зарцуулалт хийдэг тул материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн 607,998.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,120.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд ажиллаж байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих 171 талбарын мэдээллээс хугацаандаа 169 талбарын мэдээлэл, хугацаа хоцроож 2 талбарын мэдээлэл оруулсан байна. Байгууллагын батлагдсан төсөв, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулсан мэдээллийг хянаж баримтжуулсан.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 3,978.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитын системд хянаж баталгаажуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0.0	0	0.0	0.0
Албан шаардлага	1	3,978.4	1	3,978.4	100.0%
Зөвлөмж	2	0.0	2	0.0	100.0%
Нийт дүн	3	3,978.4	3	3,978.4	100.0%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал дансыг авч үзэж болох юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 661.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс 661.4 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- Санхүүгийн тайланд нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийн 661.8 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг үндсэн дансны төвлөрүүлэх шилжүүлэгтэй хамтатган дансны ангилал зөрүүтэй илэрхийлснийг санхүүгийн тайланд залруулав.

Аудитаар нийт 1,432.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 30.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,402.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын дутуу төвлөрүүлсэн 30.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын 2025.04.21-ны өдрийн А/312 дугаар захирамжаар Засаг даргын нөөц сангаас байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах засвар, цонхны хамгаалалт, интернэт сүлжээний зардалд зориулж нэмэлт санхүүжилтийн дансаараа хүлээн авч 2025.04.25-ний тухайн төлөвлөсөн арга хэмжээндээ зарцуулсан зардлын хэмнэлтээс 266.0 мянган төгрөгийг 2025 оны 09 сард төлөвлөснөөс өөр бараа материал худалдан авахад зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 47.1-д "Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно", 47.1.3-д "Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулж буй нэмэлт төсвийг тухайн зарцуулалтын эрх олгосон холбогдох арга хэмжээнээс өөр зүйлд зарцуулахгүй байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Принтерийн хор худалдан авахаар иргэн Г.Ганболдод шилжүүлсэн 156.0 мянган төгрөгийн бараа материалын орлогыг Эрдэнэт чансаа ХХК-аас, мэдээллийн самбар хийлгэхээр Уран сархиа ХХК-д шилжүүлсэн 980.0 мянган төгрөгийн барааны орлогыг иргэн А.Наранбаатараас хүлээн авч бүртгэсэн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материал хүлээлгэн өгч буй зарлагын падааныг мөнгө шилжүүлсэн нэхэмжлэгчийн нэр, хаягтай тулган шалгаж материалын орлогыг тухайн байгууллагаас хүлээн авахаар анхан шатны баримт бүрдүүлэх, хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.